



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2025. оны 04 сарын 03 өдөр

Дугаар 04.

Бор-Ө

Хөрөнгө зарцуулах тухай

Сумын Онцгой комиссын хуралдаан 2025 оны 04 сарын 03-ны өдрийн 17:00 цагт Засаг даргын Тамгын газрын ажлын байрны Иргэний танхимд 66,6 хувийн ирцтэй эхлэв.

Хуралдааныг Бор-Өндөр сумын Онцгой комиссын дарга даргалж, холбогдох асуудлыг хэлэлцэв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд баригдах Онцгой байдлын хэлтсийн барилгын талбайн инженер геологийн судалгаа хийх ажилд зарцуулагдах төсөв хэлэлцэх тухай.

2. Бумбат 3 дугаар багийн "Хайрхан" байрны усан сангийн нөөцийн сав нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй халвварт өвчин үүсгэх тулгарч байгаа тул шинээр усны нөөцийн сав худалдан авч тус багийн иргэдийг цэвэр усаар хангах асуудлыг шийдвэрлэх

СОНССОН НЬ:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын "Бор-Өндөр" 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Онцгой байдлын хэлтсийн барилга баригдах газарт инженер геологийн судалгаа хийлгэх ажлын 6 500 000 /зургаан сая таван зуун мянга/ төгрөгийг сумын Гамшгийн эрсдлийг бууруулах сангаас зарцуулах асуудлыг судалж, шийдвэрлэх

Онцгой комиссын дарга Г.Адъяабилэгт

2. Онцгой байдлын хэлтсийн барилга баригдах газарт инженер геологийн судалгааны ажилд 6.0 метрийн гүнтэй 3 ширхэг цооног малтах, 10 ширхэг дээжний үр дүнг боловсруулж, зураг, зүсэлт хийж дүгнэлт бичих ажлууд хийгдэх бөгөөд тус ажлыг "Лэнд Тэст" ХХК-тай хийсэн гэрээний дагуу гүйцэтгүүлэх

Онцгой комиссын орлогч дарга, дэд хурандаа Г.Мөнхнаран

3. Бумбат 3 дугаар багийн "Хайрхан" байрны усан сангийн нөөцийн сав нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон шалтгаанаар 2024 оны 08 сараас эхлэн ажиллуулахгүй байгаа тул урүүл ахуйн шаардлага хангасан усны нөөцийн саваар яаралтай хангаж өгөхийг хүсье.

Бумбат 3 дугаар багийн Засаг дарга Д.Мөнгөнтуяа

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг: Онцгой комиссын гишүүн, нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга
З.Ууганжаргалд:

1.1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын "Бор-Өндөр" 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Онцгой байдлын хэлтсийн барилга баригдах газарт инженер геолгийн судалгаа хийлгэх ажлын 6 500 000 /зургаан сая таван зуун мянга/ төгрөгийг "Лэнд Тэст" ХХК-тай гэрээ байгуулсан "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу сумын гамшгийн эрсдлийг бууруулах сангаас зарцуулах Захирамж төлөвлөж, санхүүжилт хийх.

1.2. Бор-Өндөр сумын Бумбат 3 дугаар багийн "Хайрхан" байрны усан сангийн нөөцийн савыг сумын Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 9 000 000 /есөн сая/ төгрөг зарцуулах Захирамж төлөвлөж, тус тус санхүүжилт хийх.

Хуралдаан 17:50 цагт дуусав.

СУМЫН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

ГАДЪЯАБИЛЭГТ

СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА БӨГӨӨД
ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

З.УУГАНЖАРГАЛ

